




**ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



**ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ**

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД**



**ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ**  
**4879 Сая АМ.ДОЛЛАР**



**ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ**  
**10.2%**



**НИЙТ ХАДГАЛАМЖ**  
**19.2 ИХ НАЯД ТӨГ**



**МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР**  
**32.4 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР**



**ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ**  
**1173 ТЭРБУМ ТӨГ**



**МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ**  
**6%**

**ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)**

ДНБ-ий өсөлт: 2021 онд: **5.1%**,  
Инфляци: 2021 онд: **8.2%**,  
Урсгал тэнцэл: 2021 онд: **-8.3%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: **6%**  
Инфляци: 2021 онд: **5.5%**,  
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: **-13.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 6-р сарын байдлаар (1070) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 12.4 хувиар өссөн бол, зарлага 19.1 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1070 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 51.3 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 0.45 төгрөгөөр буурсан байна.**

Зургаадугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 32.8 төгрөг буюу 1.2 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.45 төгрөгөөр буурч 2849.12 төгрөг болов. 5-р сард гадаад валютын нөөц 4.8 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 0.26 хувиар буурч, оны эхнээс 7.6 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 52.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




**Инфляцийн түвшин 6.6%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 6-р сарын байдлаар өмнөх сараас 0.7 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар, оны эхнээс 7 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 6 дугаар сард улсын хэмжээнд хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ тус тус өссөн байна.



**Гадаад худалдааны тэнцэл 850.2 сая.ам долларын ашигтай гарав.**

2021 оны зургаадугаар сард нийт барааны эргэлт 7372.4 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 39 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 45.3 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 850.2 сая ам.долларын ашигтай гарав.



## 6-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

Нийт хадгаламж 2021 оны 6-р сард 19.3 их наяд төгрөг болж өмнөх сараас 186.8 тэрбум төгрөг буюу 1 хувиар нэмэгдсэн бол өнгөрсөн оны мөн үеэс 25.1 хувиар буюу 3865.4 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 14974.3 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 0.7 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 4299.6 тэрбум төгрөг болж өмнөх сараас 2.1 хувиар нэмэгдэв. Үүнээс төгрөгийн хадгаламж 78 хувь, валютын хадгаламж 22 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 35.5 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 1.3 хувиар буурчээ.

## САРЫН ОНЦЛОХ

## ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ХӨТӨЛБӨР 2024 ОН ХҮРТЭЛ ҮРГЭЛЖИЛНЭ

- Монголбанк 6-р сард 75 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг банкуудад хуваарилж холбогдох гэрээний дагуу банкууд эх үүсвэрээсээ 50 тэрбум төгрөгийг нэмэн, нийт 125 тэрбум төгрөгийн ипотекийн хөтөлбөрийн зээл олгож эхлэв. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд энэ оны эхний 5 сард Монголбанк болон банкны эх үүсвэрээр нийт 327.3 тэрбум төгрөгийн зээлийг 4 426 өрхөд олгожээ. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулбал 2.2 дахин өсчээ. Өнгөрсөн 4 жилд ипотекийн хөтөлбөрийн хүрээнд сард дунджаар 32.6 тэрбум төгрөгийн зээлийг олгодог байсан бол энэ онд сард дунджаар 75.9 тэрбум төгрөгийн зээлийг олгосон нь 2.3 дахин их үзүүлэлт аж. Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн санхүүжилт 2024 он хүртэл үргэлжилнэ.

## ӨРХИЙН ДУНДАЖ ОРЛОГО БАГАСАВ

- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2021 оны эхний улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 1.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 58.6 (3.9 хувь) мянган төгрөгөөр багасаж, харин өмнөх улирлынхаас 25.5 (1.8 хувь) мянган төгрөгөөр нэмэгджээ. Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт орлогын хэмжээ энэ оны эхний улиралд 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 74.5 (6.2 хувь) мянга, өмнөх улирлынхаас 14.2 (1.2 хувь) мянган төгрөгөөр багаслаа. Өрхийн сарын дундаж бодит нийт орлогын хэмжээ өмнөх улирлынхаас 1.2 хувиар багасахад цалин хөлсний бодит орлого 37.1 (6.5 хувь) мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлөв.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 6-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 6-р сар 2021 он, Монголбанк
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)